

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДРИЙН 30 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

/Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан дүн/

Заалтын дугаар, агуулга	Биелэлт
<p>1. Санхүүгийн зах зээлийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөлтэй Хорооны зүгээс хамтран ажиллах механизмыг шинэчлэн сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийн үр өгөөжтэй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад бодитой оролцох оролцоог нь хангасан хэлбэрийг бий болгон хөгжүүлэх</p>	<p>Хорооны зүгээс санхүүгийн зах зээлийн зохицуулалтын байгууллага, тэдгээрийн төлөөллийн төрийн бус байгууллагатай зах зээлийн тогтвортой орчинг бүрдүүлэх, зохицуулалтын уян хатан хэлбэрийг сонгох, тэдгээрийн эрх хэмжээг хууль тогтоомжоор баталгаажуулах чиглэлээр хамтран ажиллаж байна.</p> <p>Тухайлбал,</p> <p>Үнэт цаасны зах зээл:</p> <p>1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар үнэт цаасны зах зээл дээрх өөрийгөө зохицуулах байгууллага болох “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны чиг үүргийг нэмэгдүүлж, Хорооны зарим чиг үүргийг тус байгууллагуудад шилжүүлсэн.</p> <p>2. “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК, холбогдох төлбөр гүйцэтгэх банк, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтарч үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн системийн зохицуулалтыг оновчтой болгох үүднээс цаг үеийн асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх зорилготой уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, үнэт цаасны зах зээл дээр үүсээд байгаа бэрхшээлийг шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.</p> <p>3. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтарч “Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын удирдах ажилтнуудын II зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан ба Төрийн өмчийн хороо, “МХБ” ХК, “ҮЦТТХТ” ХХК болон үнэт цаасны брокер дилерийн компани зэрэг 55 байгууллагын нийт 80 гаруй удирдах ажилтнуудыг хамруулж, зөвлөмж гаргасан.</p> <p>4. Үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн зуучлалын нэг цонхны үйлчилгээг хэрэгжүүлэх үүднээс данс нээх ажилбарыг хялбаршуулах Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл дээр хэлэлцүүлж Хороо, Монголбанктай хамтарч шийдвэрлэхээр ажиллаж байна.</p> <p>5. Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратегийн дагуу уг салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөний баримт бичгийн хүрээнд Хороо хуралдаанаараа хамтын шийдвэр хэлбэрээр чиглүүлж, хэрэгжүүлдэг ба цаашид ч салбарын 2016-2020 оны хөгжлийн стратегийг зах зээлийн холбогдох байгууллага, тэдгээрийн төлөөлөл, Дэлхийн банкны хамтын ажиллагааны хүрээнд тодорхойлох ажил хийгдэж байна.</p> <p>Даатгалын зах зээл:</p> <p>1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран “Хүртэмжтэй даатгал-2014” Олон Улсын форумыг зохион байгуулан уг форумд даатгалын чиглэлээр мэргэшсэн олон улсын зөвлөхүүд, гадаад орны даатгалын зохицуулагч байгууллагууд, олон улсын хөгжлийн байгууллагууд, даатгалд хамрагддаг болон даатгалын зуучлагч дотоодын хувийн хэвшлийн, санхүүгийн салбарын төлөөлөл, даатгалын компаниуд болон бусад байгууллагуудын төлөөллүүд болох 270 төлөөлөгч оролцлоо.</p>

2. Нотариатчийн хариуцлагын даатгалын тухай хуулийн төслийг боловсруулан Монголын даатгагчдын холбоо, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооноос санал авахаар хүргүүлээд байна.
3. Даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогч компаниудын удирдлага болон Даатгалын мэргэжлийн холбоодтой уулзалтыг зохион байгуулж, “Даатгалын салбарын дунд хугацааны хөтөлбөр”-ийн талаар харилцан санал солилцсоны үндсэн дээр төсөл боловсруулан Ажлын хэсэгт хүргүүлсэн.
4. Албан журмын даатгалын холбоо, даатгалын байгууллагуудтай хамтран “Албан журмын даатгал”-ын талаар уулзалт зохион байгуулж, жолоочийн албан журмын даатгалын тулгамдаж буй асуудлаар харилцан санал солилцсон бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан.
5. Шинээр болон шинэчлэн батлагдсан журам, заавар, нэмэлт өөрчлөлтийн талаар даатгалын мэргэжлийн холбоод болон даатгалын компанийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан.

Бичил санхүүгийн зах зээл:

1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийг 2013 оны 10 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралд танилцуулж, улмаар Сангийн ямаар дамжуулан УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2014.05.08 -ны өдрийн ХЭГ/833 албан тоотын дагуу хуулийн төслийг үзэл баримтлалын хамт дахин хянан боловсруулж, Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаас хуулийн төсөлтэй холбоотойгоор валлот арилжаа, барьцаалан зээлдүүлэх зэрэг санхүүгийн үйлчилгээний зохицуулалтын талаар бусад орны жишгийг судлан хуулийн төсөлд тусгах талаар нэмж судлах даалгавар өгсний дагуу холбогдох тойм судалгааг хийлээ. Сангийн яамны зүгээс эдгээр судалгааг хуулийн төслийн хамт Ерөнхий сайдад танилцуулахаар хэд хэдэн удаа хүсэлт гаргасан боловч хойшлогдож дараагийн Засгийн газрын холбогдох яамнаас дахин санал авч, үзэл баримтлалаа батлуулах болсон.
2. Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран ажиллах санамж бичгийн 2012-2013 оны хэрэгжилтийн тайланг дүгнэж, хамтран ажиллах санамж бичгийг шинэчлэн хугацаагүйгээр байгуулсан.
3. Санхүүгийн салбарын хяналт зохицуулалтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран оюутнуудын дунд “Оюуны эрэлд” эрдэм шинжилгээний хурлыг 4 үе шаттайгаар зохион байгууллаа. Нийт 4 илтгэлийг шалгаруулж, байр эзлүүлсэн.
4. Хорооны зохицуулалтын байгууллагуудын чуулга уулзалтад Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны ерөнхийлөгч “Банк бус санхүүгийн салбарын нийгэмд гүйцэтгэж буй үүрэг, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр илтгэл тавьж хамтран оролцсон.
5. МББСБХ-ны төлөөлөлтэй ажлын уулзалтуудыг зохион байгуулж, хамтын ажиллагааны үр дүн, тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн.
6. Хорооноос МББСБХ-той хамтран хийх сургалтын хөтөлбөр баталж, уг хөтөлбөрийн дагуу Хорооны дэргэд хэрэгжиж буй МОН-004 төслөөс нийт 23.200.0 мянган төгрөгийн санхүүжилтийн туслалцааг үзүүлснээр нийт 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 486 ББСБ-ын 524 ажилтан, албан хаагч хамрагдсан болно.
7. Гадаад валютын арилжааны ханшийн өсөлт, үйлчилгээний хураамжийг бууруулах, иргэд олон нийтэд энэ талаарх үнэн бодит мэдээллийг хүргэх ажлыг МББСБХ-той хамтран хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн ба дээрх чиглэлээр ББСБ-уудын удирдлагуудтай хэд хэдэн удаа тодорхой уулзалтыг зохион байгуулж ажилласан.

Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр:

1. Хөдөө аж ахуйн мэргэшсэн арилжааны зуучлагчдын холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг”-ийг 2014 оны 5 дугаар сард байгуулсан. Санамж бичгийн хүрээнд санхүүгийн зах зээлийн зохицуулалтын журмуудыг боловсруулахад Холбооноос санал авч ажиллав.

2. Санхүүгийн секторын	Банк давамгайлсан санхүүгийн зах зээлийн тогтолцооноос олон тулгуурт, төгс өрсөлдөөнт, тэнцвэрт санхүүгийн зах зээлийн
------------------------	--

<p>шинэтгэлийг эрчимтэй үргэлжлүүлэх чиглэлээрх Хорооны санаачилгыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлд үүссэн 95:5 гэсэн зохистой бус харьцааг өөрчлөх талаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд Хорооны оролцоог идэвхжүүлэх</p>	<p>тогтолцоог бий болгох, санхүүгийн зах зээлийг жигд хөгжүүлэх, нийт оролцогчдын тэгш эрхийг хангах, хамгаалах цаашдын тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн шинэтгэл, хөгжлийн бодлогыг тодорхойлсон хөтөлбөр боловсруулахаар “Санхүүгийн зах зээлийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж “Монгол улсын санхүүгийн зах зээлийн 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлээд байна.</p> <p>Хөтөлбөрт Монгол улсын санхүүгийн салбар, зах зээлийн өнөөгийн бүтцийг өөрчилж, олон тулгуурт санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи нэвтрүүлэх нутагшуулах болон санхүүгийн зах зээлийг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлэх зэргийг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлсон.</p>
<p>3. Хувьцааны хэт төвлөрөл явагдсан, Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд нь жинхэнэ утгаараа хувьцаат компани болж ажиллаж чадаагүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төдийлөн сайн хамгаалж чадахгүй байгаагийн улмаас үнэт цаасны зах зээл зогсонги байдалд орсонд дүгнэлт хийж үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>Үнэт цаасны арилжааг нь зогсоосон 165 ХК-ийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах ажлын хэсгийг Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТГХТ” ХХК –ийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Уг ажлын хэсэг үнэт цаасны зах зээлийг идэвхижүүлэхэд эхний ээлжинд хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, өмч хөрөнгийг нь үрэгдүүлсэн, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироож буй дээрх 165 ХК-ийн асуудлыг шийдвэрлэн, Хөрөнгийн биржийн бүртгэлийг цэвэрлэх зорилго тавин ажилласан. Ажлын хэсэг үнэт цаасны арилжааг нь зогсоосон 110 ХК-ийг</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгийн биржийн бүртгэлээс хассан 57 ХК; 2. Тогтмол биш боловч санхүүгийн тайлан болон хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулж байсан 35 ХК, 3. Татан буугдаж харъяа аймаг, дүүргийн Улсын бүртгэл, татварын хэлтсийн бүртгэлээс хасагдсан, эрх зүйн чадамжгүй болсон 17 ХК гэж 3 хэсэгт ангилсан. <p>Хуулиар хүлээсэн үүргээ огт биелүүлээгүй 57 ХК-ийн тухайд: Хорооноос нэр бүхий 57 ХК-ийн гаргасан үнэт цаасыг “МХБ” ХК-ийн бүртгэлээс хасах зөвшөөрөл олгох шийдвэр гаргасантай холбогдуулан дээрх компаниудын жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дараахи арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Хорооноос арилжааг нь зогсоосон бүх хувьцаат компаниудын удирдлагуудад хандан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасан хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах, тулгараад буй нөхцөл байдлын талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, компанийн цаашдын хувь заяаны талаар хэлэлцэн шийдвэрлэх, үйл ажиллагаагаа сэргээн явуулах эсэх, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, компанийг татан буулгах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлтээ Хороонд тавьж шийдвэрлүүлэх талаар хугацаатай үүргийг 2013 оны 08 дугаар сард өгч, Хорооны болон “МХБ” ХК-ийн цахим хуудас, “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” сонинд тус тус анхааруулга, мэдэгдлийг нийтлүүлсэн. Одоогийн байдлаар дээрх компаниудаас 9 ХК-ийн удирдлагууд бидний тавьсан шаардлагын дагуу компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасуулах асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Тогтмол биш боловч санхүүгийн тайлан болон хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулж байсан 35 ХК-ийн тухайд: Дээрх 57 ХК-иас ялгаатай нь эдгээр компаниуд нь холбоо барих эзэнтэй, зарим нь үйл ажиллагаа бага зэрэг явуулдаг, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт харьцангуй сайн гэж үзэж болохоор байгаа бөгөөд бүх компаниудын удирдлага, хувьцаа эзэмшигчдэд компанийн ирээдүйн төлөв байдал, чиг хандлагыг тодорхойлж, цаашид зохион байгуулалтын хувьд хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах эсэх, эсхүл бүртгэлээс үнэт цаасаа хасуулах хүсэлтийг тавьж шийдвэрлүүлэхийг 2013 оны 8 дугаар сард үүрэг өгч, Хороо, “МХБ” ХК-ийн цахим хуудсаар дамжуулан холбогдох мэдээллийг нийтэд түгээсэн.</p> <p>Татан буугдаж харъяа аймаг, дүүргийн Улсын бүртгэл, татварын хэлтсийн бүртгэлээс хасагдсан, эрх зүйн чадамжгүй болсон 17 ХК-ийн тухайд: Арилжааг нь зогсоосон хувьцаат компаниудаас 17 хувьцаат компани аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, татварын албанаас ирүүлсэн судалгаагаар татан буугдсан гэсэн мэдээлэл байсан ба энэ хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газраас дахин компани тус бүрээр лавлагаа авч, татан буугдсан үндэслэл холбогдох нотлох баримтыг цуглуулах ажиллагааг хийлээ. Ингэснээр татан буугдаж Улсын бүртгэл, татварын хэлтсийн бүртгэлээс хасагдсан, хуулийн</p>

	<p>этгээдийн эрх зүйн чадамжгүй, хуулийн этгээдийн статусгүй болсон 13 хувьцаат компани байгааг тогтоосон болно. Дээрх ажлын дүнд нэр бүхий 12 ХК-ийн гаргасан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлээд байна.</p>
<p>4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг алслагдмал орон нутгийн иргэдэд хүргэх хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгааг анхааралдаа авч, тэдгээрийн үйлчилгээний хүрээг тэлэх, зохицуулалтын оновчтой бодлого боловсруулж, орон нутагт тохирсон банк бус санхүүгийн үйлчилгээний шинэ загвар бүтээгдхүүн нэвтрүүлэх, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга механизмыг сайжруулах, Төв банктай энэ чиглэлээр хамтран ажиллах</p>	<p>Банк бус санхүүгийн үйл ажиллагааг алслагдмал орон нутгийн иргэд хүргэх, талаар дараах арга хэмжээг авч ажилласан.</p> <ol style="list-style-type: none"> 1. Алслагдсан дүүрэг болон орон нутагт банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүрмийн сангийн доод хэмжээг ялгавартай тогтоож, орон нутгуудад санхүүгийн өдөрлөг уулзалтуудыг зохион байгуулсан. Үүний үр дүнд орон нутагт 15 ББСБ, 6 ХЗХ шинээр байгуулагдсан. 2. Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Хорооны зүгээс бодлогоор дэмжиж, Хамтран ажиллах гэрээ байгуулж нийт 87 ХЗХ-дод тусгай зөвшөөрөл, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөл олгосон. 3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулах тухай хуулийн төсөлд банк бус санхүүгийн үйлчилгээний шинэ загвар бүтээгдэхүүн нэвтрүүлэх, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга механизмын зохицуулалтыг оруулсан. Уг төслөөр банк бус санхүүгийн үйл ажиллагааг валют солих цэг, зээлийн байгууллага, банк бус санхүүгийн байгууллага гэж 3 ангилан, хууль батлагдсантай холбогдон гарах журмуудаар Хорооноос тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавих нөхцөл шаардлага, хяналт зохицуулалтыг байгууллагын төрлийн хувьд 3, үйл ажиллагаа явуулж буй байршилаар, хот хөдөө гэж 2 түвшинд авч үзэхээр тусгах юм. Ингэснээр санхүүгийн зуучлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхийг төрөөс бодлогоор дэмжих, түүнд тавигдах шаардлага, хориглох зүйл болон хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, тухай салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашдын тогтвортой хөгжилд ач холбогдолтой арга хэмжээ болно.
<p>5. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр валютын биржийн тогтолцооны талаарх асуудлыг хэлэлцүүлж, валютын үйл ажиллагаанд зохицуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох, 2014 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлтэй уялдуулах</p>	<p>Валютын үйл ажиллагаанд зохицуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бий болгох валютын захын талаар олон улсын практик, валютын биржийн үйл ажиллагааны талаарх ойлголт, түүний бүтэц, зохион байгуулалт, хяналт зохицуулалтын талаар судалгаа хийсэн.</p> <p>Валютын бирж байгуулах асуудлаар Монголбанктай санал солилцож, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанд валютын дуудлага худалдаанд ББСБ оруулах асуудлыг танилцуулж хэлэлцүүлсний дүнд Худалдаа Хөгжлийн Банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон валютын арилжааны эрхтэй ББСБ-ууд хамтран “Хамтын ажиллагааны гурван талт гэрээ” байгуулсан ба ингэснээр ББСБ-ууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн оролцох боломж нээгдсэн.</p>
<p>6. Бичил санхүүгийн болон банк бус санхүүгийн байгууллагуудыг зээлийн мэдээллийн санд бүрэн хамруулах, зээлийн хүүг бууруулах бодлогын орчинг бий болгох</p>	<p>Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ББСБ, ХЗХ-дод Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулахыг үүрэг болгож, Хорооны www.frc.gov.mn цахим хуудсаас зээлийн мэдээллийн санд өгөгдөл дамжуулах “Micro finance” програмыг гарын авлагын дагуу үнэ төлбөргүйгээр суулган ашиглахыг зөвлөсөн. Үүний үр дүнд 2014 оны эцсээр 52 ХЗХ, 178 ББСБ-аас зээлийн мэдээллийн сантай холбогдон зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг үйл ажиллагаандаа авч ашиглаж байна.</p> <p>Зээлийн хүүг бууруулах бодлогын хүрээнд БСХС-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ББСБ-ыг бөөний зээлд хамруулах ажлыг хийж байгаа бөгөөд 32 ББСБ 15,8 тэрбум төгрөгийн зээлийг бага хүүтэйгээр 1350 харилцагчид олгосон нь салбарын хэмжээнд зээлийг хүүг бууруулахад ач холбогдол өгч байна. Цаашид хямд эх үүсвэрийг бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан зээлийн хүүг бууруулах талаар холбогдох байгууллага, яамдтай хамтран ажиллана.</p>
<p>7. Иргэд, даатгуулагчдын санхүүгийн болон даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, харилцагчдын эрх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Харилцагчдын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам” болон “Ердийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”- журамд тус тус өөрчлөлт орууллаа. 3. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн "Бичил даатгалын чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийг амжилттай хэрэгжүүлж, иргэдэд зориулсан 2 төрлийн бичил даатгалын бүтээгдэхүүнийг даатгалын компаниудтай хамтран боловсруулж, зах зээлд нэвтрүүлсэн.

<p>ашгийг хамгаалах, үндэсний давхар даатгалын компани байгуулах талаар судалгаа хийж, үндэслэл боловсруулах</p>	<p>Уг төслийн хүрээнд албан журмын болон бичил даатгалын талаарх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор 4 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт "Даатгалын мэдээллийн төв"-ийг 2014 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарыг дуустал ажиллуулсан.</p> <p>4. Даатгалын зуучлагчдын холбоотой хамтран 2014 оны 1 дүгээр улирлын байдлаар Улаанбаатар хотод 2 удаа, орон нутагт 10 удаа даатгалын сургалт зохион байгуулсан ба сургалтад нийт 467 хүн сургалтад хамрагдсан.</p> <p>5. Үндэсний давхар даатгалын тогтолцоог буй болгох судалгааг Дэлхийн банкны дэмжлэгээр хийж, дотоодын 2, олон улсын 1 зөвлөхийг шалгаруулан, Үндэсний давхар даатгалын тогтолцооны судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, 2014 оны 5 дугаар сард Сангийн яаманд, 2014 оны 9 дүгээр сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.</p>
<p>8. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах</p>	<p>Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Төлбөр тооцог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг салбарын хэмжээнд мөрдөгддөг 20-иод хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зохицуулалтын байгууллагуудын хүрээнд тогтмол хийж байна. 2014 онд хууль тогтоомж зөрчсөн давхардсан тоогоор 97 аж ахуйн нэгж байгууллагад 150 сая төгрөгийн торгууль шийтгэвэр ногдуулан ажилласан байна.</p> <p>Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нэр бүхий 20 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, хууль зөрчсөн барилгын 3, тээвэр зуучийн 6 хуулийн этгээдэд 13.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналт хийх үүрэг бүхий ажилтныг 158 хадгаламж зээлийн хоршоо, 332 банк бус санхүүгийн байгууллагад томилуулан хэрэгжилтийг хангууллаа. Төсвийн орлого, хураамжийг гадаад валютаар төвлөрүүлэх нь дээрх хуулийг зөрчсөн үйлдэл болж байсан тул төсвийн орлого, хураамж төвлөрүүлдэг банкин дахь гадаад валютын харилцах дансыг хаах асуудлыг Сангийн яамтай хамтран шийдвэрлэлээ.</p>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2013 ОНЫ 05 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН
12 ДУГААР ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**
/Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцсэн тухай/

Заалтын дугаар, агуулга	Биелэлт
<p>1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан уг хуулийг 2014 оноос хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлыг Улсын Их хурлаас гаргасан тогтоолын дагуу шуурхай зохион байгуулж, дүнг 2013 оны 12 дугаар сард багтаан ЭЗБХ-нд танилцуулах</p>	<p>Улсын Их Хурлаас 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлснээр манай улсын үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болох, томоохон компаниуд хувьцаагаа гаргах, давхар бүртгүүлэн арилжих, ингэснээр урт хугацаат хөрөнгө оруулалтын эх үүсвэр татах таатай боломж бий болсон. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд шинээр 32 журам баталж, 12 журамд нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Мөн 2013 оны 72 дугаар тогтоолоор нэр бүхий 11 арилжааны банкинд Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч арилжаанд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Хуулийн хэрэгжилтийг хангуулахаар УИХ-ын 2013 оны 41 дүгээр тогтоол гарсан бөгөөд тогтоолоор өгсөн үүргийн биелэлтийг гарган 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/4863 тоот албан бичгээр ЭЗБХ-нд хүргүүлсэн.</p>
<p>2. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу жил бүр үйл ажиллагааны тайландаа Хууль зүйн яамнаас боловсруулсан аргачлалын дагуу системчилсэн үнэлгээ хийж байх зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>	<p>Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийх ажлыг ажлын хэсэг гарган зохион байгууллаа. Ажлын хэсэг байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийхдээ Хууль зүйн яамнаас боловсруулсан аргачлалын дагуу явуулж үнэлэлт өгч зөвлөмж гаргав.</p>
<p>3. Тус Байнгын хорооноос 2012 онд өгч байсан чиглэлийн дагуу Компанийн тухай хуулийн хэрэгжилтийг холбогдох, яам газруудтай хамтран шалгаж, дүнг 2013 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулах</p>	<p>2012 онд тус Хороо УИХ-ын тогтоолын холбогдох заалтын дагуу Компанийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо болон нэгдсэн чуулганд танилцуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар “Хувьцаат компани нь жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулсан байх” үүргийг нийт 162 ХК хэрэгжүүлээд байна. 2. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаа тус Хороонд ирүүлж, энэ талаар нийтэд мэдээлсэн нийт 204 ХК байна. 3. Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасныг 161 ХК хэрэгжүүлэн өөрийн дүрмийг шинэчлэн баталж, улсын бүртгэлийн

	<p>байгууллагад бүртгүүлээд байна.</p> <p>4. Компанийн тухай хуулийн 75.4-д заасан ”Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 болон түүнээс доошгүй гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3/1-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна” гэсний дагуу нийт 122 ХК төлөөлөн удирдах зөвлөлдөө хуульд заасан хэмжээний хараат бус гишүүдийг сонгосон байна.</p> <p>5. Өнгөрсөн онд нийт 30 ХК 11.4 тэрбум төгрөгийн ноогдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан бөгөөд эдгээрээс Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжиж, жижиг хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан дүн нь 1.1 тэрбум орчим төгрөг байна.</p> <p>Санхүүгийн зохицуулах хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хувьцаат компанийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажиллаж байгаа бөгөөд өнгөрөгч онд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл аймгуудад үйл ажиллагаа явуулж буй нийт 21 ХК-д хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд шалгалт хийсэн байна.</p>
<p>4.Монгол улсад Компанийн засаглалыг сайжруулах ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах хүрээнд уг асуудлыг хариуцаж байгаа Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай төсөв хөрөнгийг 2014 оны Улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авах</p>	<p>“Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хорооны 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэлийн төсвийн төсөлд Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай үйл ажиллагааны урсгал зардлын төслийг 463.9 сая төгрөгөөр тооцоолон санал хүргүүлснээс 331.1 сая төгрөгөөр батлуулан авч, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн ажиллаж байна.</p>
<p>5.Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээрх сургалт, сурталчилгааны төв байгуулах төсөв, зардлыг Улсын төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх талаар идэвхтэй ажиллаж, холбогдох зардлын тооцоо, саналаа танилцуулах, Улсын Их Хурлаас байгуулагдан түүнд ажлаа тайлагнадаг байгуулагуудын төсвийг хэлэлцэн баталдаг одоогийн практик үйл ажиллагаа, дэгийг шинэчлэн өөрчлөх саналыг боловсруулж Улсын Их хурлаар шийдвэр гаргуулах</p>	<p>2014 оны улсын төсвийн Хөрөнгө оруулалтаар барилгын их засварт 204.2 сая төгрөг батлагдсан боловч Төсвийн тодотголоор хасагдсан болно. Хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, нэмэлт тооцоолол, саналаа Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар нарт тус тус хүргүүлэв.</p>
<p>6.Тайлан хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүдийн хэлсэн санал, дүгнэлт, зөвлөмжүүдийг үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авах</p>	<p>2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 зүйлээр 78 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ба төлөвлөгөөнд УИХ-ын гишүүдээс өгсөн санал дүгнэлт болох иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр өгөгдсөн үүргүүд тусгагдсан болно. Мөн гадны төслүүдээс техникийн дэмжлэг аван сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж байна.</p>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО